

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/261/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 261885 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn</p> <p>Аудитор: С.Болортуяа Утас: 261885 Цахим хаяг: bolortuyas@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Сүлд-Аудит” ХХК-ийн захирал: Ч.Гүндбаяр Утас: 70118016 Цахим хаяг: info@suld-audit.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	15
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	19
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал.....	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	21
5.1 Төлбөрийн акт	22
5.2 Албан шаардлага	22
5.3 Зөвлөмж.....	23
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	25
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл.....	25
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл.....	26
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	27

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГБХНЯ	Гэр Бүл, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам
НББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
СНАГ	Санхүү-Нийцлийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/358

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 65,393.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна Тухайлбал:

- “Дөл-Оюу Дөл” ХХК-д протезын үйлдвэрийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор олгосон 1,552,301.6 мянган төгрөгийн зээлийн авлагын үлдэгдлээс 10,000.0 мянган төгрөгийг зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөлт хийгдээгүй;
- Тухайн байгууллагын дотоод хяналт хангалтгүйгээс 2022 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвд балансаас балансад шилжүүлсэн 21,700.0 мянган төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгийн бүртгэлээс хасалт хийгээгүйгээс тухайн хөрөнгөнд 2023-2024 онуудад элэгдэл тооцсон зэрэг зөрчлүүд илэрсэн.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1, 72.4.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн

18 дугаар зүйлийн 18.1-ын заалтуудтай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын үнэн зөв болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 119,504.0 мянган төгрөгийн, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрийн дагуу 1,078,562.0 мянган төгрөгийн, нийт 1,198,066.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын "Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний аргачлал, заавар, үйлчилгээний үнэ тариф, гэрээний загвар батлах тухай" 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/53 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих өдрийн үйлчилгээний (Дэмжих төв) үнэ тариф"-г шинэчлэн тогтоосны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, хөгжлийн үйлчилгээ үзүүлэх дэмжих төвүүдийг нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар зохион байгуулж, шаардлага хангасан 12 байгууллагыг сонгон шалгаруулж 3,902,169.1 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 чиглэл, 22 дэд зорилтын хүрээнд 61 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 88.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийг дэмжих зорилгоор Засгийн газрын 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 212 дугаар тогтоолоор Өмнөговь аймагт 7 дахь төвийг байгуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,579,044,054.50	1,573,389,110.74
33	АВЛАГА	1,576,283,985.50	1,569,735,011.74
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	23,982,385.50	31,187,624.07
33500	Бусад авлага	-	245,787.67
33520	Хувь хүмүүсээс авах авлага	-	245,787.67
33600	Зээлийн авлага	1,552,301,600.00	1,538,301,600.00
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	1,552,301,600.00	1,538,301,600.00
33615	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	1,552,301,600.00	1,538,301,600.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,760,069.00	3,654,099.00
35400	Хангамжийн материал	2,760,069.00	3,654,099.00
35410	Бичиг хэргийн материал	1,395,870.00	889,910.00
35420	Аж ахуйн материал	52,800.00	52,800.00
35470	Бусад хангамжийн материал	1,311,399.00	2,711,389.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,235,508,734.16	4,251,863,714.06
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,235,508,734.16	4,251,863,714.06
39200	Биет хөрөнгө	3,164,865,294.16	3,151,330,129.60
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,500,167,535.00	3,500,167,535.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(533,685,189.59)	(601,638,446.87)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	67,900,000.00	74,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(27,725,833.17)	(34,515,833.13)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	232,366,272.00	330,170,222.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(127,176,423.42)	(163,076,309.89)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	72,107,540.88	82,107,540.88
39208	Хуримтлагдсан элэгдэл	(28,874,600.14)	(46,014,132.55)
39214	Бусад үндсэн хөрөнгө	12,801,884.80	4,551,884.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	(11,015,892.20)	(3,322,330.64)
39217	Ном	8,000,000.00	8,000,000.00
39300	Биет бус хөрөнгө	70,643,440.00	1,100,533,584.46
39303	Бусад биет бус хөрөнгө	71,413,440.00	1,142,975,440.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(770,000.00)	(42,441,855.54)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,814,552,788.66	5,825,252,824.80
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,241,598.01	5,000,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,241,598.01	5,000,000.00
41300	Өглөг	5,241,598.01	5,000,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	5,241,598.01	-
41360	Бусад өглөг	-	5,000,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	5,000,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,809,311,190.65	5,820,252,824.80
51	Засгийн газрын хувь оролцоо	4,809,311,190.65	5,820,252,824.80
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,474,849,925.14	1,474,849,925.14
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	1,474,849,925.14	1,474,849,925.14
51200	Хуримтлагдсан үр дүн	705,527,185.69	1,716,468,819.84
51210	Өмнөх үеийн үр дүн	817,690,020.92	705,527,185.69
51220	Тайлант үеийн үр дүн	(112,162,835.23)	1,010,941,634.15
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,628,934,079.82	2,628,934,079.82
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,814,552,788.66	5,825,252,824.80

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,688,698,670.00	7,200,811,437.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	103,512,200.00	7,200,811,437.00
120	Нийтлэг татварын бус орлого	103,512,200.00	1,198,065,950.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	825,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	825,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	102,687,200.00	1,198,065,950.00
122	Тусламжийн орлого	-	6,002,745,487.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	6,002,745,487.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	6,001,955,087.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	6,001,955,087.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	790,400.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	790,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,585,186,470.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,407,833,300.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,407,833,300.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	177,353,170.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	175,848,170.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,505,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,742,657,755.40	6,189,869,802.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,742,657,755.40	6,189,869,802.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,933,203,676.07	5,747,099,140.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	963,705,644.84	1,188,442,977.77
210101	Үндсэн цалин	582,811,780.96	640,090,998.75
210102	Нэмэгдэл	173,689,639.80	264,397,161.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	129,536,478.73	195,340,300.00
210104	Урамшуулал	77,667,745.35	88,614,517.59
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	206,785,683.57	150,949,700.00
210201	Тэтгэврийн даатгалын зардал	150,027,883.49	102,799,700.00
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	14,189,500.08	12,093,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	7,094,700.00	6,047,000.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	7,094,700.00	6,047,000.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	28,378,900.00	23,962,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,613,558.33	97,503,942.48
210301	Гэрэл, цахилгаан	17,414,308.18	40,904,601.62
210302	Түлш, халаалт	22,214,866.61	28,163,415.66
210303	Цэвэр, бохир ус	21,984,383.54	28,435,925.20
2104	Хангамж, бараа материалын зардал	29,506,642.00	38,204,019.26
210401	Бичиг хэрэг	6,278,920.00	8,870,660.00
210402	Тээвэр, шатахуун	151,594.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,409,215.00	11,509,424.26
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,001,916.00	17,823,935.00
210408	Бараа материал акталсны зардал	2,664,997.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,390,000.00	506,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	143,000.00
210604	Урсгал засвар	1,390,000.00	363,000.00

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2107	Томилолт, зочны зардал	-	27,620,000.00
210702	Дотоод албан томилолт	-	27,620,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	350,379,571.00	4,052,161,530.57
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	334,534,571.00	4,045,507,626.57
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	14,900,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	425,000.00	268,304.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,000.00	71,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	441,000.00	1,292,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	319,822,576.33	191,710,970.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	184,866,096.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	134,956,480.33	191,710,970.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,809,454,079.33	442,770,662.67
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	348,752,697.21
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	348,752,697.21
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн саан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	348,752,697.21
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	333,962,297.21
2131122	Төсвийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	14,000,000.00
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	790,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,644,000.00	94,017,965.46
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	94,017,965.46
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,644,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,802,810,079.33	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,801,305,079.33	
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,505,000.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(53,959,085.40)	1,010,941,634.15
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	58,203,749.83	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	58,203,749.83	
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(58,203,749.83)	
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(112,162,835.23)	1,010,941,634.15

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,599,992,070.00	6,002,745,487.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	825,000.00	6,002,745,487.00
120	Нийтлэг татварын бус орлого	825,000.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	825,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	825,000.00	-
122	Тусламжийн орлого	-	6,002,745,487.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	6,002,745,487.00
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	6,001,955,087.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	6,001,955,087.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	790,400.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	790,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,599,167,070.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,407,833,300.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,407,833,300.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	191,333,770.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	189,828,770.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,505,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,599,995,970.00	6,006,745,487.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,599,995,970.00	6,006,745,487.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,790,541,890.67	5,563,974,824.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	987,688,030.34	1,198,752,117.59
210101	Үндсэн цалин	606,794,166.46	643,194,900.00
210102	Нэмэгдэл	173,689,639.80	271,602,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	129,536,478.73	195,340,300.00
210104	Урамшуулал	77,667,745.35	88,614,517.59
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	177,368,300.00	150,949,700.00
210201	Тэтгэврийн даатгалын зардал	120,610,500.00	102,799,700.00
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	14,189,500.00	12,093,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал аатгал	7,094,700.00	6,047,000.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	7,094,700.00	6,047,000.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	28,378,900.00	23,962,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,613,558.33	97,265,942.48
210301	Гэрэл, цахилгаан	17,414,308.18	40,816,601.62
210302	Түлш, халаалт	22,214,866.61	28,013,415.66
210303	Цэвэр, бохир ус	21,984,383.54	28,435,925.20
2104	Хангамж, бараа материалын зардал	27,644,961.00	39,072,049.26
210401	Бичиг хэрэг	7,275,650.00	8,293,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,409,215.00	11,509,424.26
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,960,096.00	19,269,225.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,390,000.00	506,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	143,000.00
210604	Урсгал засвар	1,390,000.00	363,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	20,820,000.00
210702	Дотоод албан томилолт	-	20,820,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	345,008,271.00	4,056,609,015.00

**Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

	төлбөр, хураамж		
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	329,163,271.00	4,054,955,111.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	14,900,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	425,000.00	268,304.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,000.00	71,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	441,000.00	1,292,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	189,828,770.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	189,828,770.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,809,454,079.33	442,770,662.67
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		348,752,697.21
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг		348,752,697.21
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		348,752,697.21
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		333,962,297.21
2131122	Төсвийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		14,000,000.00
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал		790,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,644,000.00	94,017,965.46
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	94,017,965.46
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,644,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,802,810,079.33	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,801,305,079.33	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,505,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(3,900.00)	(4,000,000.00)
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	14,000,000.00
140003	Бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт		14,000,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	10,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	10,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	10,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		10,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	4,000,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(3,900.00)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,900.00	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,474,849,925.14	2,628,934,079.82	796,568,333.49	4,900,352,338.45
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			21,121,687.43	21,121,687.43
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,474,849,925.14	2,628,934,079.82	817,690,020.92	4,921,474,025.88
Тайлант үеийн үр дүн			(112,162,835.23)	(112,162,835.23)
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,474,849,925.14	2,628,934,079.82	705,527,185.69	4,809,311,190.65
2025 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	1,474,849,925.14	2,628,934,079.82	705,527,185.69	4,809,311,190.65
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,474,849,925.14	2,628,934,079.82	705,527,185.69	4,809,311,190.65
Тайлант үеийн үр дүн			1,010,941,634.15	1,010,941,634.15
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,474,849,925.14	2,628,934,079.82	1,716,468,819.84	5,820,252,824.80

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	8,758,123,500.00	5,667,992,789.79	3,090,130,710.21	64.7
12	Татварын бус орлого	8,758,123,500.00	5,667,992,789.79	3,090,130,710.21	64.7
122	Тусламжийн орлого	8,758,123,500.00	5,667,992,789.79	3,090,130,710.21	64.7
122005	Төсвөөс санхүүжих	8,758,123,500.00	5,667,992,789.79	3,090,130,710.21	64.7
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,758,123,500.00	5,667,992,789.79	3,090,130,710.21	64.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,758,123,500.00	5,667,992,789.79	3,090,130,710.21	64.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,663,063,500.00	5,573,974,824.33	3,089,088,675.67	64.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,212,470,000.00	1,198,752,117.59	13,717,882.41	98.9
210101	Үндсэн цалин	643,194,900.00	643,194,900.00	-	100.0
210102	Нэмэгдэл	271,602,400.00	271,602,400.00	-	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	195,340,300.00	195,340,300.00	-	100.0
210104	Урамшуулал	102,332,400.00	88,614,517.59	13,717,882.41	86.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	150,950,400.00	150,949,700.00	700.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	102,799,700.00	102,799,700.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	12,094,000.00	12,093,300.00	700.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,047,000.00	6,047,000.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	6,047,000.00	6,047,000.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	23,962,700.00	23,962,700.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	207,882,600.00	97,265,942.48	110,616,657.52	46.8
210301	Гэрэл, цахилгаан	94,832,700.00	40,816,601.62	54,016,098.38	43.0
210302	Түлш, халаалт	67,988,000.00	28,013,415.66	39,974,584.34	41.2
210303	Цэвэр, бохир ус	45,061,900.00	28,435,925.20	16,625,974.80	63.1
2104	Хангамж, бараа материалын зардал	81,431,700.00	48,372,049.26	33,059,650.74	59.4
210401	Бичиг хэрэг	8,437,000.00	8,293,400.00	143,600.00	98.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,673,900.00	11,509,424.26	10,164,745.74	53.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,281,200.00	-	8,281,200.00	0.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	43,039,600.00	28,569,225.00	14,470,375.00	66.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,573,600.00	506,000.00	8,067,600.00	5.9
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	8,210,600.00	143,000.00	8,067,600.00	1.7
210604	Урсгал засвар	363,000.00	363,000.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	61,540,000.00	20,820,000.00	40,720,000.00	33.8
210702	Дотоод албан томилолт	61,540,000.00	20,820,000.00	40,720,000.00	33.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,940,215,200.00	4,057,309,015.00	2,882,906,185.00	58.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,925,644,400.00	4,055,655,111.00	2,869,989,289.00	58.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,242,200.00	-	8,242,200.00	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	403,100.00	268,304.00	134,796.00	66.6
210804	Тээврийн хэрэгслийн татвар	340,400.00	71,000.00	269,400.00	20.9
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	268,800.00	22,000.00	246,800.00	8.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,345,300.00	1,292,600.00	2,052,700.00	38.6
210807	Газрын төлбөр	1,971,000.00	-	1,971,000.00	0.0

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	95,060,000.00	94,017,965.46	1,042,034.54	98.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	95,060,000.00	94,017,965.46	1,042,034.54	98.9
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	95,060,000.00	94,017,965.46	1,042,034.5	98.9
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-	-	-
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
62	Ажиллсагсадын тоо	32	29	3	90.6
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	29	26	3	89.7
620003	Үйлчлэх ажилтан	2	2	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл /төгрөгөөр/
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН		790,400.00
12	Татварын бус орлого		790,400.00
122	Тусламжийн орлого		790,400.00
1221	Хандив тусламж /дотоод/		790,400.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого		790,400.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		790,400.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ		790,400.00
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		(790,400.00)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт		(790,400.00)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын эрхэм зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжил, хамгааллын талаарх Засгийн газрын бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангах, бие даан хөгжих чадварыг эзэмшүүлэх замаар амьдралын чанарыг нь дээшлүүлэхэд оршино.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар нь хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш эрх болон нийгмийн хамгааллын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих, хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд бүрэн дүүрэн оролцох, ая тухтай амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлийн талаарх эерэг ойлголт, хандлагыг олон нийтэд төлөвшүүлэх, тэдэнд ээлтэй нийгмийн орчныг бүрдүүлэх, сэтгэл зүй, эрүүл мэндийн хувьд нөхөн сэргээхэд чиглэсэн үйл ажиллагааг явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллагын үйл ажиллагаандаа Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Татварын багц хууль, Боловсролын тухай багц хуулиуд, Гэр бүлийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиудыг мөрдлөг болгон хэрэгжүүлдэг байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд тайлант онд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 8, 12, 14, 16, 28, 57, 68 дугаар зүйлүүдэд 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан
- Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” 43 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 238 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2025 оны “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 52 дугаар тогтоол

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах/ шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа нь Нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлагналдаа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үндэслэн холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/136 дугаар тушаалаар НБББББ-ийг батлан, мөрдөж ажиллаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,010,700.0 мянган төгрөгөөр буюу 17.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	1,576,284.0	1,569,735.0	(6,549.0)
Бараа материал	2,760.0	3,654.1	894.0
Үндсэн хөрөнгө	3,235,508.7	4,251,863.7	1,016,355.0
Нийт хөрөнгө	4,814,552.8	5,825,252.8	1,010,700.0
Өр төлбөр	5,241.6	5,000.0	(241.6)
Засгийн газрын оруулсан капитал	1,474,849.9	1,474,849.9	-
Хуримтлагдсан үр дүн	705,527.2	1,716,468.8	1,010,941.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,628,934.1	2,628,934.1	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,814,552.8	5,825,252.8	1,010,700.0

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөр болон хуримтлагдсан үр дүнгийн дансдуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл 1,569,735.0 мянган төгрөг болж 6,549.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд хувь хүнээс авах авлага 245.8 мянган төгрөг, ажиллагчидтай холбоотой авлага 7,205.2 мянган төгрөг, Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээлийн эргэн төлөлт 14,000.0 мянган төгрөг тус тус төлөгдсөн.
- Бараа материалын дансны үлдэгдэл 3,654.1 мянган төгрөг болж 894.0 мянган төгрөгөөр өссөн нь тендерийн сонгон шалгаруулалт нэмэгдсэнтэй холбоотой бичиг хэргийн материалын үлдэгдэл өссөн нь нөлөөлсөн.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,251,863.7 мянган төгрөг болж 1,016,355.0 мянган төгрөгөөр өссөн нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 119,504.0 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмж, мөн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын зөвшөөрлөөр 1,078,562.0 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн үнэ төлбөргүй хүлээн авч, Архивын шүүгээ 10,000.0 мянган төгрөгөөр худалдан авсан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 07 дугаар сарын 04-ны А/135 зөвшөөрлийн дагуу анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгийг акталж, тайлант хугацааны 191,710.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал гарсантай холбоотой.
- Өр төлбөр дансны үлдэгдэл 5,000.0 мянган төгрөг болж, 241.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд байгууллагад төлөх өглөгөө төлсөнтэй холбоотой.

Нийт үйл ажиллагааны зардал өмнөх оноос 2,447,212.0 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар нь Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн “ACOLOUS” төсөвт байгууллагын санхүүгийн программыг ашигладаг бөгөөд тайлант онд программ хангамжтай холбоотой зардал гараагүй болно.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 8,775,768.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 450,335.3 мянган төгрөгөөр бууруулан, бусдаар гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 4,051,772.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 12,377,205.7 мянган төгрөгөөр баталсан.

Төсвийн тодотголоор 11 дүгээр сард урсгал төсвийг 3,619,082.2 мянган төгрөгөөр бууруулан 8,758,123.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 8,758,123.5 мянган төгрөгийг улсын төсвөөс олгохоор баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 6,001,955.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, гүйцэтгэлээр 5,667,992.8 мянган төгрөгийг зарцуулж, 333,962.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,667,992.8 мянган төгрөг буюу 64.7 хувьтай байгаа нь цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 13,718.6 мянган төгрөг, байрны түрээсийн зардлыг 110,616.7 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 33,059.7 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 8,067.6 мянган төгрөг, томилолт, зочны зардлыг 40,720.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардлыг 4,057,309.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

						/мянган төгрөгөөр/
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувь/
1	72206	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн	8,758,123.5	5,667,992.8	3,090,130.7	64.7
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,814,026.1	1,593,840.0	220,186.1	87.9
1.2	80219	Харуул, хамгаалалтын зардал	58,125.0	57,740.0	385.0	99.3
1.3	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	43,360.0	94,018.0	50,658.0	216.8
1.4	81569	Төр зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	152,674.9	20,225.7	132,449.2	13.2
1.5	83115	Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрүүд	6,689,937.5	3,902,169.1	2,787,768.4	58.3

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч үр дүнг тайланд тусгалаа. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн А/18 дугаар тушаалаар 35 хүний орон тоогоор батлагдаж, Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 52 дугаар тогтоолоор орон тоог 10 хувиар бууруулан 32 хүний орон тоогоор шинэчлэн баталсан байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/191 дүгээр тушаалаар нэг өдрийн хоол унааны зардлыг 30.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон байна. Тайлант онд 195,340.3 мянган төгрөгийн хоол унааны зардал гарсан байна.
- Тайлант онд нийт 12 удаагийн сургалт зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөнд 68,610.6 мянган төгрөгийн зардал гарсан байна.
- Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 358 дугаар тогтоол, мөн Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 128/ШШ2024/0757 дугаар шийдвэрийн дагуу ажлаас чөлөөлөгдсөн 2 ажилтныг эргүүлэн томилж, ажилгүй байсан хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг тооцож нөхөн бичилт хийсэн. Байгууллагаас 7,205.2 мянган төгрөгийг тайлант онд нийгмийн даатгалд төлж, буруутай этгээдээс авах авлага үүсгэн бүртгэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 2,205.0 мянган төгрөгийн тендерийн орлогыг бүрдүүлж, шуудан, холбоо, интернэтийн төлбөрт 1,414.6 мянган төгрөгийг зарцуулж, 790.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 2 бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар 8,058,320.0 мянган төгрөгийг баталж гүйцэтгэлээр гэрээний дагуу 3,959,909.1 мянган төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгч байгууллагад шилжүүлсэн байна. Үүнд:

- Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, хөгжлийн үйлчилгээ үзүүлэх дэмжих төвүүдийг сонгон шалгаруулах ХБХХЕГ/20250103007 дугаартай тендерийг нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар зохион байгуулж, шаардлага хангасан 12 байгууллагатай гэрээ байгуулан 620 хүүхдэд үйлчилгээ үзүүлж, нийт 3,902,169.1 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.
- Гэрээт харуул хамгаалалтын үйлчилгээг эрхлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ХБХХЕГ/20240203001 дугаартай тендерийг харьцуулалтын аргаар зохион байгуулж, шалгарсан байгууллагатай 58,125.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан. Тайлант хугацаанд 57,740.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг зөв тайлагнах, зардлын ангилалтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Сүлд-Аудит” ХХК-ийн аудитор Г.Төрсайхан, туслах аудитор Б.Баттогтох, Н.Цэрэндулам нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер С.Лхагважав, захирал Ч.Гүндбаяр нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүү аудитын газрын аудитор С.Болортуяа, аудитын менежер А.Цогбаяр, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 1/60 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,800,861.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцож, 38,008.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хэмнэх боломжтой зардлуудыг хэмнэх дараах арга хэмжээ авч ажилласан байна. Үүнд:

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага нь шатахуун болон 3 аймгийн томилолтын зардал гаргалгүй, цахимаар зохион байгуулж төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд урсгал засварын зардлыг хэмнэн ажилласантай холбоотой.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 5,850.0 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 5,850.0 мянган төгрөгийн 1 гүйлгээг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг хуулийн хугацаанд, үнэн зөв, иж бүрэн мэдээлэхгүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрийн хүрээнд санхүүжилт авсан төрийн бус байгууллагуудын өмнөх сарын гүйцэтгэлийг нь хянаагүй байхад дараагийн сарын санхүүжилтийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын тушаалаар олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.2-т "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;", 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай тус тус нийцээгүй байна

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрийн хүрээнд санхүүжилт авсан төрийн бус байгууллагуудын өмнөх сарын гүйцэтгэлийг цаг хугацаанд нь хянаж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

2. "Дэл-Оюу Дөл" ХХК-д 2021 оны 06-р сарын 17-ны өдрийн 10 дугаартай "Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн үйл ажиллагааг дэмжих эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийн гэрээ"-ний хүрээнд 1,552,301.6 мянган төгрөгийн зээл олгосон байна. Зээлийн эргэн төлөлт нь батлагдсан графикийн дагуу төлөлт бүрэн хийгдээгүй байхад Дэл-Оюу Дөл" ХХК-ийн хүсэлтийн дагуу үндсэн гэрээний хугацааг 15 жилээр буюу 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрөөс 2040 оны 06 дугаар сарын 16-ны өдрийг хүртэл хугацаагаар сунгасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, ер төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Дэл-Оюу Дөл" ХХК-ийн авсан зээлийн эргэн төлөлтөд тавих хяналтыг сайжруулах, хугацаандаа төлөгдөөгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн худалдан авах ажиллагаа нь ТБОНӨХБАУХА тухай хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, зээлийн эргэн төлөлт, үндсэн хөрөнгө, авлага, өглөг, цалин, орлого, зардал дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Завсрын аудитаар 2,606.8 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 23,982.4 мянган төгрөгийн 1 зөрчилтэй холбоотой анхан шатны баримтыг бүрдүүлж, шилэн дансны 5,850.0 мянган төгрөгийн 1 мэдээг нөхөн байршуулаагүй, 1,371,074.5 мянган төгрөгийн зөвлөмжийн биелэлт хангалтгүй тул аудитын тайланд тусгасан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 144,846.0 мянган төгрөгийн 4 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж, зээлийн эргэн төлөлттэй холбоотой 609,900.0 мянган төгрөгийн албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй, аудитын шийдвэрийн хэрэгжилт 17.5 хувьтай байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	1,399.4	2	1,399.4	100.0
Албан шаардлага	6	835,746.0	4	144,846.0	17.3
Нийт дүн	8	837,145.4	6	146,245.4	17.5

Өмнөх онд "Дэл-Оюу Дөл" ХХК-д протезын үйлдвэрийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор олгосон 1,552,301.6 мянган төгрөгийн зээлийн авлага бүртгэлтэй ба зээлийн эргэн төлөлтийн графикайн дагуу тайлант хугацаанд зээлийн эргэн төлөлт хугацаандаа хийгдээгүй боловч өмнөх албан шаардлагыг хэрэгжүүлэх талаар ажлын хэсэг байгуулж өр авлагыг барагдуулах талаар тодорхой ажлыг хийсэн байна. Зээлийн авлагыг эргэн төлөгдөх хуваарийн дагуу барагдуулалт хийгдээгүй тул зээлийн эргэн төлөлтөд тавих хяналтыг сайжруулах, хугацаандаа төлөгдөөгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлуудыг дараагийн аудитаар авч үзэх, дээд шатны байгууллага анхаарал хандуулах шаардлагатай байна. Үүнд:

- "Дэл-Оюу Дөл" ХХК-д 2021 оны 06-р сарын 17-ны өдрийн 10 дугаартай "Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн үйл ажиллагааг дэмжих эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийн гэрээ"-ний гүйцэтгэлийг хянах;
- Тус байгууллагын хэрэгжүүлж байгаа нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрийн хүрээнд санхүүжилт авсан төрийн бус байгууллагуудын санхүүжилтийг гүйцэтгэлд суурилж олгох асуудлыг хянах;

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 56,037.6 мянган төгрөгийн 4 алдаа¹ илэрснийг аудитын явцад бүрэн залруулсан. Үүнд:

Залруулсан алдаа:

- Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 358 дугаар тогтоол, мөн Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх-ийн 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 128/ШШ2024/0757 дугаар шийдвэрийн дагуу ажлаас чөлөөлөгдсөн 2 ажилтныг тус тус үүрэгт ажилд нь эргүүлэн томилж ажиллаагүй нөхөн олговрыг холбогдох хууль журмын хүрээнд тооцоож олгосон төлөгдөөгүй 23,982.4 мянган төгрөгийн авлагыг зардлаар бүртгэж, данснаас хасалт хийсэн байна. .

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 358 дугаар тогтоол, мөн Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх-ийн 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 128/ШШ2024/0757 дугаар шийдвэрийн дагуу ажлаас чөлөөлөгдсөн 2 ажилтныг эргүүлэн томилж, ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг нөхөн олгон, нийгмийн даатгалын шимтгэлийг тооцож нөхөн бичилт хийсэн байна. Үүний дагуу нийт 7,205.2 мянган төгрөгийг байгууллагаас төлсөн боловч уг зардлыг буруутай албан хаагчаас авах авлага үүсгэн бүртгээгүй байна.
- Мөнгөн гүйлгээний тайланд бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлтийг тайлагнаагүй нь байна.
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/1/1981 дугаар "Зөвшөөрөл олгох тухай" тушаалаар 1 нэрийн /TobiiDynavox snap scene/ эмнэлгийн тоног төхөөрөмжийг балансаас балансад шилжүүлэх зөвшөөрөл олгож, тухайн хөрөнгийг бүртгэлээс хасч, тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн байна. Тухайн хөрөнгө бодит байдал дээр байхгүй байхад элэгдэл тооцсон байна.

Эдгээр алдаанууд нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга 27 дугаар параграфф "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээний нөлөөг УСНББОУС-д шударгаар илэрхийлэхийг шаарддаг", санхүүгийн тайлангийн үнэн зөв болон толилуулга батламж мэдэгдлүүдийг хангаагүй.

Аудитаар нийт 65,393.1 мянган төгрөгийн 7 зөрчил² илэрсэнээс, 8,333.3 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 39,920.0 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 17,139.8 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 65,393.1 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 27,384.5 мянган төгрөгөөр давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих зорилгоор хүүхдүүдэд танхимаар үзүүлэх өдрийн үйлчилгээний зардлын тайланд хяналт хийхэд үйлчилгээ аваагүй 5 хүүхдийн 8,333.3 мянган төгрөгийн санхүүжилтийг "Бяцхан гэрэлт цох" цэцэрлэгт олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.2-т "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих"; 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ." гэж заасантай тус тус нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих танхимаар үзүүлэх өдрийн үйлчилгээнд хамрагдаагүй хүүхдүүдэд олгосон санхүүжилтийг тооцоолол хийсэн, хянасан, шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов

5.2 Албан шаардлага

1. Газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн Б/35 дугаар тушаалыг үндэслэн мэдээлэл технологийн асуудал хариуцсан мэргэжилтэнд 2024 оны 8 дугаар сарын 01-нээс

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2025 оны 10 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд унаа, хоолны хөнгөлөлтийн 8,220.0 мянган төгрөгийг олгоогүй байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам”-ын 8.2. “Нийтийн тээврийн тогтмол үйлчилгээтэй хот суурин газарт ажиллаж байгаа энэ журмын 8.1-д зааснаас бусад төрийн албан хаагч нь ажилдаа ирэх, буцахад нийтийн тээврийн хэрэгслээр зорчих зайлшгүй шаардлагатай бол нийтийн тээврийн унааны зардлын 50 хувийг байгууллагаас нь нөхөн олгоно.”, 8.4. “Төрийн албан хаагчийн өдрийн хоолны зардлын тодорхой хэсгийг байгууллагаас нөхөн олгоно.”, 2025 оны 7 дугаар сарын 19-нд байгуулсан Хөдөлмөрийн гэрээний 3.4. “Гэрээт ажилтанд олгох цалин хөлсийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хугацаанд нь олгох.”, 2025 оны 7 дугаар сарын 18-ний өдөр шинэчлэн байгуулсан Хөдөлмөрийн гэрээний 3.4. “Ажилтанд олгох үндсэн болон нэмэгдэл цалин хөлс, тэтгэмж, олговор зэргийг холбогдох хууль, тогтоомж, хөдөлмөрийн дотоод журмын дагуу олгох.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Мэдээлэл технологийн асуудал хариуцсан мэргэжилтэнд унаа, хоолны хөнгөлөлтийг олгоогүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

2. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/1/1981 дугаар “Зөвшөөрөл олгох тухай” тушаалаар 1 нэрийн 21,700.0 мянган төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн тоног төхөөрөмжийг (TobiiDynavox snap scene) балансаас балансад шилжүүлэх зөвшөөрөл олгосны дагуу 2022 онд холбогдох байгууллагад хүлээлгэн өгсөн боловч 2023-2024 онуудын жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогыг үнэн зөв хийгээгүйгээс тус хөрөнгөнд хуримтлагдсан элэгдэл тооцсон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1 “Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах”, 72.4.4 “Комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх”, гэж тус тус заасантай нийцээгүй байна

Шийдвэрлэсэн нь: Эд хөрөнгийн тооллогыг үнэн зөв хийж, нягтлан бодох бүртгэлийн хуулийг хэрэгжүүлж ажиллахгүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

3. Зээлийн эргэн төлөлтийн графикийн дагуу тайлант онд төлөх 10,000.00 мянган төгрөгийн зээлийг төлөөгүй, хугацаа хэтэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, ер төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: “Дэл-Оюу Дөл” ХХК-ийн авсан зээлийн эргэн төлөлтөд тавих хяналтыг сайжруулах, хугацаандаа төлөгдөөгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэхээр төлөвлөсөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний зөвлөлийн гишүүдийн 9,453.0 мянган төгрөгийн урамшууллын нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг үндсэн цалин хөлсний зардлаас гарган зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулахдаа холбогдох дээд шатны байгууллагаас зөвшөөрөл авч, гүйцэтгэлийг бодитой тайлагнаж байх.

2. Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хөгжлийн бэрхшээлтэй үндэсний зөвлөлийн 10 гишүүдээс 6 гишүүний урамшууллын нийгмийн даатгалын тайлагнахдаа шимтгэлийн буруу хувь хэмжээгээр тайлагнаснаас 648.8 мянган төгрөгөөр зөрүүтэй шилжүүлсэн.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 3.2-д "Нийгмийн даатгалын шимтгэл төлөх, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал олгох, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх харилцааг зөвхөн нийгмийн даатгалын хууль тогтоомжоор зохицуулна", 17.1-д заасан "Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг нийгмийн даатгалын тайланд үнэн зөв, зөрүүгүй тайлагнаж байх.

3. Зардлын эдийн засгийн ангилалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд гэрэл, цахилгаан, түлш, халаалтын зардлаас 238.0 мянган төгрөгийг бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардал /210406/-д мөн дотоод албан томилолтын 6,800.0 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд нийт 7,038.0 мянган төгрөгийн зардлыг эдийн засгийн ангилал зөрүүлж бүртгэсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7 Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно", 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулахдаа холбогдох дээд шатны байгууллагаас зөвшөөрөл авч, гүйцэтгэлийг бодитой тайлагнаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж			
		Тоо		Дүн		Тоо		Дүн		Залруулсан		Залруулаагүй		Тоо Дүн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 358 дугаар тогтоол, мөн Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх-ийн 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 128/ШШ2024/0757 дугаар шийдвэрийн дагуу ажлаас чөлөөлөгдсөн 2 ажилтныг тус тус үүрэгт ажилд нь эргүүлэн томилж ажиллаагүй нөхөн олговорыг холбогдох хууль журмын хүрээнд тооцоож олгосон төлөгдөөгүй 23,982.4 мянган төгрөгийн авлагыг зардлаар бүртгэж, данснаас хасалт хийсэн байна.	1	23,982.4			1	23,982.4			1	23,982.4				
2	Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 358 дугаар тогтоол, мөн Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх-ийн 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 128/ШШ2024/0757 дугаар шийдвэрийн дагуу ажлаас чөлөөлөгдсөн 2 ажилтныг эргүүлэн томилж, ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг нөхөн олгон, нийгмийн даатгалын шимтгэлийг тооцож нөхөн бичилт хийсэн байна. Үүний дагуу нийт 7,205.2 мянган төгрөгийг байгууллагаас төлсөн боловч уг зардлыг буруутай албан хаагчаас авах авлага үүсгэн бүртгээгүй байна.	1	7,205.2			1	7,205.2			1	7,205.2				
3	Мөнгөн гүйлгээний тайланд бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлтийг тайлагнаагүй.			1	14,000.0					1	14,000.0				
4	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/1/1981 дугаар "Зөвшөөрөл олгох тухай" тушаалаар 1 нэрийн ТobiiДулавох snar scene/ эмнэлгийн тоног төхөөрөмжийг балансаас балансад шилжүүлэх зөвшөөрөл олгож, тухайн хөрөнгийг бүртгэлээс хасч, тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн байна. Тухайн хөрөнгө бодит байдал дээр байхгүй байхад элэгдэл тооцсон байна.					1	10,850.0			1	10,850.0				
	Дүн	4	56,037.6	1	14,000.0	3	42,037.6	4	56,037.6						

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

	Нийт зөрчил	Үүнээс										
		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөрчлийн товч утга	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн Б/35 дугаар тушаалыг үндэслэн мэдээлэл технологийн асуудал хариуцсан мэргэжилтэнд 2024 оны 8 дугаар сарын 01-нээс 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд унаа, хоолны хөнгөлөлтийн 8,220.0 мянган төгрөгийг олгоогүй байна			1	8,220.0								
Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэхээр төлөвлөсөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний зөвлөлийн гишүүдийн урамшууллын нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг үндсэн цалин хөлсний зардлаас гарган зарцуулсан байна.					1	9,453.0						
Хөгжлийн бэрхшээлтэй үндэсний зөвлөлийн 10 гишүүдээс 6 гишүүний урамшууллын нийгмийн даатгалын тайлагнахдаа шимтгэлийн буруу хувь хэмжээгээр тайлагнаснаас 648.8 мянган төгрөгөөр зөрүүтэй шилжүүлсэн.					1	648.8						
Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/1/1981 дугаар "Зөвшөөрөл олгох тухай" тушаалаар 1 нөрийн 21,700.0 мянган төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн тоног төхөөрөмжийг (TobiiDyavox snap scene) балансаас балансад шилжүүлэх зөвшөөрөл олгосны дагуу 2022 онд холбогдох байгууллагад хүлээлгэн өгсөн боловч 2023-2024 онуудын жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллыг үнэн зөв хийгээгүйгээс тус хөрөнгөнд хуримтлагдсан элэгдэл тооцсон байна			1	21,700.0								
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих зорилгоор хүүхдүүдэд танхимаар үзүүлэх өдрийн үйлчилгээний зардлын тайланд хяналт хийхэд үйлчилгээ аваагүй 5 хүүхдийн 8,333.3 мянган төгрөгийн санхүүжилтийг "Бяцхан гэрэл цох" цэцэрлэгт олгосон байна		1	8,333.3									
Зээлийн эргэн төлөлтийн графикийн дагуу тайлант онд төлөх 10,000.00 мянган төгрөгийг зээлийг төлөөгүй, хугацаа хэтэрсэн байна.				1	10,000.0							
Тайлант онд гэрэл, цахилгаан, түлш, халаалтын зардлаас 238.0 мянган төгрөгийг бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардал /210406/-д мөн дотоод албан томилолтын 6,800.0 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд нийт 7,038.0 мянган төгрөгийн зардлыг эдийн засгийн ангилал зөрүүлж бүртгэсэн.					1	7,038.0						
Дүн	7	65,393.1	1	8,333.3	3	39,920.0	3	17,139.8	3	17,139.8	-	-

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээнээс 5,850.0 мянган төгрөгийн 1 мэдээллийг тайлагнаагүй байна.	1	5,850.0			1	5,850.0		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрийн хүрээнд санхүүжилт авсан төрийн бус байгууллагуудын өмнөх сарын гүйцэтгэлийг нь хянаагүй байхад дараагийн сарын санхүүжилтийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын тушаалаар олгосон байна.	1	-			1	-		
"Дэл-Оюу Дел" ХХК-д "2021 оны 06-р сарын 17-ны өдрийн 10 дугаартай "Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн үйл ажиллагааг дэмжих эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийн гэрээ"-ний хүрээнд 1,552,301.6 мянган төгрөгийн зээл олгогдсон байна. Зээлийн эргэн төлөлт нь батлагдсан графикайн дагуу төлөгдөөгүй байхад жэрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдөр уг гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, үндсэн гэрээний хугацааг 15 жилээр буюу 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрөөс 2040 оны 06 дугаар сарын 16-ны өдрийг хүртэл хугацаагаар гэрээг сунгасан.	1	-			1	-		
Нийт дүн	3	5,850.0	-	-	3	5,850.0	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 74/АД150169

Улаанбаатар хот

САГ-2026/267/НА-СТА-ТУЛЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих зорилгоор хүүхдүүдэд танхимаар үзүүлэх өдрийн үйлчилгээний зардлын тайланд хяналт хийхэд үйлчилгээ аваагүй 5 хүүхдийн 8,333,333.00 /найман сая гурван зуун гучин гурван мянга гурван зуун гучин гурван төгрөгийн санхүүжилтийг "Бяцхан гэрэлт цох" цэцэрлэгт олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах.", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.2-т "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих"; 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журал"-ын 4.2.3.8 "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж тус тус заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих танхимаар үзүүлэх өдрийн үйлчилгээнд хамрагдаагүй хүүхдүүдэд олгосон 8,333,333.00 (найман сая гурван зуун гучин гурван мянга гурван зуун гучин гурван) төгрөгийг олгох шийдвэр гаргасан Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга Д.Гэрэлээр төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга /Д.Гэрэл/, ерөнхий нягтлан бодогч /О.Содномпэрэнлэй/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:
АУДИТЫН МЕНЕЖЕР:
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ:



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Ч.ГҮНДБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 370/A0150169

Улаанбаатар хот

САГ-2026/261/НА -СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- "Дэл-Оюу Дөл" ХХК-д "2021 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 10 дугаартай "Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн үйл ажиллагааг дэмжих эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийн гэрээ"-ний хүрээнд 1,552,301,600.00 төгрөгийн зээл олгогдсон байна. Зээлийн эргэн төлөлт нь батлагдсан графикайн дагуу төлөлт бүрэн хийгдээгүй байхад "Дэл-Оюу Дөл" ХХК-ийн хүсэлтийн дагуу үндсэн тэрээний хугацааг 15 жилээр буюу 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрөөс 2040 оны 06 дугаар сарын 16-ны өдрийг хүртэл хугацаагаар сунгасан.
- Зээлийн эргэн төлөлтийн графикайн дагуу тайлант онд төлөх 10,000,000.00 /Арван сая/ төгрөгийн зээлийг төлөөгүй, хугацаа хэтэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10 "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. "Дэл-Оюу Дөл" ХХК-ийн авсан зээлийн эргэн төлөлтөд тавих хяналтыг сайжруулж, хугацаандаа төлөгдөөгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга /Д.Гэрэл/, ерөнхий нягтлан бодогч /О.Содномпэрэнлэй/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:
АУДИТЫН МЕНЕЖЕР:
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ:



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Ч.ГҮНДБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 371/А0150169

Улаанбаатар хот

САГ-2026/261/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн Б/35 дугаар тушаалыг үндэслэн мэдээлэл технологийн асуудал хариуцсан мэргэжилтэнд 2024 оны 8 дугаар сарын 01-нээс 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд унаа, хоолны хөнгөлөлтийн 8,220,000.00 /найман сая хоёр зуун хорин мянган/ төгрөгийг олгоогүй байна.


Энэ нь Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам"-ын 8.2. "Нийтийн тээврийн тогтмол үйлчилгээтэй хот суурин газарт ажиллаж байгаа энэ журмын 8.1-д зааснаас бусад төрийн албан хаагч нь ажилдаа ирэх, буцахад нийтийн тээврийн хэрэгслээр зорчих зайлшгүй шаардлагатай бол нийтийн тээврийн унааны зардлын 50 хувийг байгууллагаас нь нөхөн олгоно", 8.4 "Төрийн албан хаагчийн өдрийн хоолны зардлын тодорхой хэсгийг байгууллагаас нөхөн олгоно.", 2025 оны 7 дугаар сарын 19-нд байгуулсан Хөдөлмөрийн гэрээний 3.4 "Гэрээт ажилтанд олгох цалин хөлсийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хугацаанд нь олгох", 2025 оны 7 дугаар сарын 18-ний өдөр шинэчлэн байгуулсан Хөдөлмөрийн гэрээний 3.4 "Ажилтанд олгох үндсэн болон нэмэгдэл цалин хөлс, тэтгэмж, олговор зэргийг холбогдох хууль, тогтоомж, хөдөлмөрийн дотоод журмын дагуу олгох" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.18 "Байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Мэдээлэл технологийн асуудал хариуцсан мэргэжилтэнд унаа, хоолны хөнгөлөлтийг олгоогүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга /Д.Гэрэл/, ерөнхий нягтлан бодогч /О.Содномпэрэнлэй/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:
АУДИТЫН МЕНЕЖЕР:
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ:



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР

Ч.ГҮНДБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-66.Docx

1526180816



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 372/А0150169

Улаанбаатар хот

САГ-2026/261/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/1/1981 дугаар "Зөвшөөрөл олгох тухай" тушаалаар 1 нэрийн 21,700.000.00 /Хорин нэгэн сая долоон зуун мянган/ төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн тоног төхөөрөмжийг (TobiiDynavox snap scene) балансаас балансад шилжүүлэх зөвшөөрөл олгосны дагуу 2022 онд холбогдох байгууллагад хүлээлгэн өгсөн байна. Харин 2023-2024 онуудын жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогыг үнэн зөв хийгээгүйгээс тайлант онуудад бүртгэлтэй байснаас тус хөрөнгөнд хуримтлагдсан элэгдэл тооцсон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1 "Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах", 72.4.4 "Комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх", гэж тус тус заасантай нийцээгүй байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.2 "Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр балансаас балансад шилжүүлсэн хөрөнгийг тооллогын бүртгэлд тусгасан, хуримтлагдсан элэгдэл тооцож үр дүнг буруу тайлагнасан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга /Д.Гэрэл/, ерөнхий нягтлан бодогч /О.Содномпэрэнлэй/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:
АУДИТЫН МЕНЕЖЕР:
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ:



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР

Ч.ГҮНДБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3 Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-66.Docx

1526180818



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 373/A0150169

Улаанбаатар хот

САГ-2026/261/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрийн хүрээнд санхүүжилт авсан төрийн бус байгууллагуудын өмнөх сарын гүйцэтгэлийг нь хянаагүй байхад дараагийн сарын санхүүжилтийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын тушаалаар олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.2-т "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих," 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцээгүй байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4."Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрийн хүрээнд санхүүжилт авсан төрийн бус байгууллагуудын өмнөх сарын гүйцэтгэлийг цаг хугацаанд нь хянаж, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга /Д.Гэрэл/, ерөнхий нягтлан бодогч /О.Содномпэрэнлэй/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:
АУДИТЫН МЕНЕЖЕР:
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ:



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Ч.ГҮНДБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 429/A0150169

Улаанбаатар хот

САГ - 2026/261/НА - СГА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 5,850,000.00 /Таван сая найман зуун тавин мянга/ төгрөгийн 1 гүйлгээг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10 "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг хуулийн хугацаанд, үнэн зөв, иж бүрэн мэдээлэхгүй байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга /Д.Гэрэл/, ерөнхий нягтлан бодогч /О.Содномпэрэнлэй/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:
АУДИТЫН МЕНЕЖЕР:
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ:



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР

Ч.ГҮНДБАЯР